



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 27157

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 тоот тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын "Хэрлэнгийн хурд" Морин спортын уяачдын холбооноос зохион байгуулагдсан Төвийн бүсийн бага 3 насны хурдан морьдын уралдааныг 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр "Өндөрхаан хайрханы" энгэрт нийт уяачдад нээлттэйгээр зохион байгуулахад зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулагдах 4.962.000 (дөрвөн сая есөн зуун жаран хоёр мянган) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ӨРДЭНЭБААТАР